

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2023/222/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр 2023 он	Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор: Б.Авидцэрэн Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

ШШГГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.2 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын нөөцөөс нэн шаардлагатай санхүүжилт болох 19.5 сая төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллагад бүртгэлтэй агуулахын зориулалттай 195.5 сая төгрөгийн өртөгтэй газрын эзэмших эрхийг өмнөх онд аймгийн Засаг даргын А/547 тоот захирамжаар хүчингүй болгосон боловч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүй тул хөрөнгийн бүртгэлээс хасагдаагүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	74947755.00	79754932.06
35	БАРАА МАТЕРИАЛ	74947755.00	79754932.06
351	Түүхий эд материал	38755781.10	42853458.11
35110	Тусгай зориулалттай материал	37840091.10	38607683.11
35130	Эм боох материал	915690.00	4245775.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4059567.90	7552068.45
354	Хангамжийн материал	32132406.00	29349405.50
35410	Бичиг хэргийн материал	635050.00	936750.00
35420	Аж ахуйн материал	28436000.00	26042430.00
35430	Сэлбэг хэрэгсэл	142000.00	142000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	1548182.00	1468502.00
35460	Хүнсний материал	584650.00	759723.50
35470	Бусад хангамжийн материал	786524.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1239072752.63	1269706816.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1239072752.63	1269706816.20
39200	Биет хөрөнгө	1002342957.65	1030699316.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1002438526.79	1002438526.79
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-60486161.40	-80772061.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216938166.00	90630000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	-211738166.00	-78788333.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	112368402.11	121931099.07
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	-85223059.79	-54434029.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40248543.30	46377341.30
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	-15679617.36	-20159550.60
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног	3476324.00	3476324.00
39300	Биет бус хөрөнгө	236729794.98	239007500.02
39301	Програм хангамж	6417692.31	3862692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	-6395897.33	-1563192.29
39303	Бусад биет бус хөрөнгө	236708000.00	236708000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1314020507.63	1349461748.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1314020507.63	1349461748.26
51	Засгийн газрын хувь оролцоо	1314020507.63	1349461748.26
51101	-Төрийн	336189592.54	336189592.54
51200	Хуримтлагдсан үр дүн	861949680.37	897390921.00
51210	Өмнөх үеийн үр дүн	870830967.38	861973013.62
51220	Тайлант үеийн үр дүн	-8881287.01	35417907.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115881234.72	115881234.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1314020507.63	1349461748.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	623148903.91	693080469.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45880603.91	50077869.97
1200	Нийтлэг татварын бус орлого	45880603.91	50077869.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45880603.91	50077869.97
1200041	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		80000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45880603.91	49997869.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	577268300.00	643002600.00
1310	Улсын төсвөөс	570879300.00	623502600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570879300.00	623502600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6389000.00	19500000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	6389000.00	19500000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	632030190.92	657662562.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	632030190.92	657662562.59
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627902628.22	655759465.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	429801800.38	438921646.63
210101	Үндсэн цалин	288090353.34	301804671.87
210102	Нэмэгдэл	137116947.04	137116974.76
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4594500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8479726.95	8926038.97
210201	Тэтгэврийн даатгал		161584.80
210202	Тэтгэмжийн даатгал		19009.97
210203	ҮОМШӨ-ний даатгал		15207.98
210204	Ажилгүйдлийн даатгал		3802.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8479726.95	8726434.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57596000.00	62388651.20
210301	Гэрэл, цахилгаан	9850400.00	10552051.20
210302	Түлш, халаалт	36998500.00	39120000.00
210303	Цэвэр, бох ир ус	10747100.00	12716600.00
2104	Ханга мж, бараа материалын зардал	25561443.10	26798062.00
210401	Бичиг хэрэг	3711400.00	3687500.00
210402	Тээвэр, шатах уун	13411300.00	15206800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1578636.90	1355900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		51300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1412950.00	1378400.00
210408	Бараа материал акталсны зардал		5118162.00
2105	Нормативт зардал	37965155.45	50699477.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1509080.00	3891015.00
210502	Хоол, хүнс	35608046.05	45550226.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	848029.40	1258236.45
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4900898.00	12573180.00
210604	Урсгал засвар	4900898.00	12573180.00
2107	Томилот, зочны зардал	75300.00	0.00
210702	Дотоод албан томилот	75300.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5115400.00	3577066.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1737800.00	1790200.00
210803	Даатгалын үйлчилгээ	327300.00	327300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	557000.00	460266.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154000.00	129500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554500.00	554500.00
210807	Газрын төлбөр	1784800.00	315300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58406904.34	51875342.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	415912.50	410200.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1240000.00	2000000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	56750991.84	49465142.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4127562.70	1903097.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	336000.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	336000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	3205800.00	420000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3205800.00	420000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	585762.70	1483097.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	585762.70	1483097.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	-8881287.01	35417907.38
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	-8881287.01	35417907.38

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336189592.54	115881234.72	870830967.38	1322901794.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336189592.54	115881234.72	870830967.38	1322901794.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-8881287.01	-8881287.01
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336189592.54	115881234.72	861949680.37	1314020507.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	23333.25	23333.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	336189592.5	115881234.7	861973013.6	1314043840.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	0	0	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0	0	0	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			35417907.38	35417907.38
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336189592.5	115881234.7	897390921.0	1349461748.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	577288300.00	643082600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20000.00	80000.00
120	Нийтлэг татварын бус орлого	20000.00	80000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20000.00	80000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20000.00	80000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	577268300.00	643002600.00
1310	Улсын төсвөөс	570879300.00	623502600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570879300.00	623502600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6389000.00	19500000.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	6389000.00	19500000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	570963403.64	606611200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	570963403.64	606611200.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	566835840.94	604708102.80
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	429802223.45	438921646.63
210101	Үндсэн цалин	288090353.34	301414589.80
210102	Нэмэгдэл	137117370.11	137507056.83
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4594500.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8479726.95	8926038.97
210201	Тэтгэврийн даатгал	0.00	66333.61
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	7803.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	6243.16
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1560.79
210205	Эрүүл мэндийн даатгал	8479726.95	8844097.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57596000.00	62388651.20
210301	Гэрэл, цахилгаан	9850400.00	10552051.20
210302	Түлш, халаалт	36998500.00	39120000.00
210303	Цэвэр, бохир ус	10747100.00	12716600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17827036.90	22001600.00
210401	Бичиг хэрэг	2390800.00	3857200.00
210402	Тээвэр, шатахуун	12742800.00	15206800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1578636.90	1355900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61000.00	51300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1053800.00	1530400.00
2105	Нормативт зардал	37085000.00	52633900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1907300.00	6908600.00
210502	Хоол, хүнс	35177700.00	45725300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8309400.00	13298000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2000000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	177900.00	149500.00
210604	Урсгал засвар	6131500.00	13148500.00
2107	Томиллолт, зочны зардал	75300.00	0.00
210702	Дотоод албан томиллолт	75300.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5231553.64	3577066.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1853953.64	1790200.00
210803	Даатгалын үйлчилгээ	327300.00	327300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	557000.00	460266.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	154000.00	129500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554500.00	554500.00
210807	Газрын төлбөр	1784800.00	315300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2429600.00	2961200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1189600.00	961200.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1240000.00	2000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4127562.70	1903097.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	336000.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	336000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3205800.00	420000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3205800.00	420000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	585762.70	1483097.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	585762.70	1483097.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	6324896.36	36471400.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6324900.00	36471400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6324900.00	36471400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6324900.00	36471400.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6324900.00	36471400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-6324900.00	-36471400.00
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-3.64	0.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3.64	0
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	623,567,600.00	622,099,502.80
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	623,567,600.00	622,099,502.80
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	623,147,600.00	621,679,502.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,259,400.00	173,831,817.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	439,117,000.00	438,921,646.63
210101	Үндсэн цалин	287,648,500.00	301,414,589.80
210102	Нэмэгдэл цалин	148,864,500.00	137,507,056.83
210103	Унаа хоолны нэмэгдэл	1,116,000.00	0.00
210104	Урамшуулал	1,488,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,771,200.00	8,926,038.97
210201	Тэтгэврийн даатгал	0.00	66,333.61
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	7,803.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	6,243.16
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,560.79
210205	Эрүүл мэндийн даатгал	9,771,200.00	8,844,097.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,390,000.00	62,388,651.20
210301	Гэрэл, цахилгаан	10,553,400.00	10,552,051.20
210302	Түлш, халаалт	39,120,000.00	39,120,000.00
210303	Цэвэр, бохир ус	12,716,600.00	12,716,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,001,600.00	22,001,600.00
210401	Бичиг хэрэг	3,857,200.00	3,857,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,206,800.00	15,206,800.00
210403	Шуудан,холбоо, интернетийн төлбөр	1,355,900.00	1,355,900.00
210405	Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	51,300.00	51,300.00
210406	БҮТЭЗүйлс	1,530,400.00	1,530,400.00
2105	Нормативт зардал	46,633,900.00	46,633,900.00
210501	Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	908,600.00	908,600.00
210502	Хоол хүнс	45,725,300.00	45,725,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,270,300.00	38,269,400.00
210601	Багаж,техник хэрэгсэл	24,972,300.00	24,971,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	149,500.00	149,500.00
210604	Урсгал засвар	13,148,500.00	13,148,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,002,400.00	3,577,066.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,215,500.00	1,790,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	327,300.00	327,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	460,300.00	460,266.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	129,500.00	129,500.00
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	554,500.00	554,500.00
210807	Газрын төлбөр	315,300.00	315,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	961,200.00	961,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	961,200.00	961,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,000.00	420,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	623,567,600.00	622,099,502.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	65,000.00	80,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	623,502,600.00	622,019,502.80
131001	Улсын төсвөөс санхүүжих	623,502,600.00	622,019,502.80

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		19,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		19,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		19,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,500,000.00
2105	Нормативт зардал		6,000,000.00
210501	Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		6,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,500,000.00
210601	Багаж,техник хэрэгсэл		11,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,000,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		19,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		19,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,500,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хорих байрны тухай, Хорих байрны харуул хамгаалалтын тухай, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тухай, Эрүүгийн тухай, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж томилогдсон ба ажлын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу иргэн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэл, хүний тоо бүртгэл, эмнэлэг, архив бичиг хэрэг, сургалт хүний нөөцийн үйл ажиллагаанд шалгалт зохион байгуулж ажилласан байна. Мөн өмч хамгаалах байнгын комисс 5 бүрэлдэхүүнтэй, тушаал гаргаж төлөвлөгөө боловсруулан байгууллагын өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, бараа материалын худалдан авалтад тухай бүр хяналт тавин ажилладаг.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн

зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2020 онд баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж ажилладаг.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35.4 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	74,947.8	79,754.9	4,807.1
Үндсэн хөрөнгө	1,239,072.7	1,269,705.8	30,633.1
Нийт хөрөнгө	1,314,020.5	1,349,461.7	35,440.2
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,314,020.5	1,349,461.7	35,440.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,314,020.5	1,349,461.7	35,440.2

Дээрх хүснэгтээс харахад:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 30.6 сая төгрөгөөр өссөн байгаа нь хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмж болон аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон санхүүжилтээр бэлтгэсэн автомашин орлогод авсан, мөн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлж, шинээр үнэ тогтоосонтой холбоотой байна.

- Бараа материалын үлдэгдэл 4.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын онцлогоос хамаардаг хоригдлын хувцас, зөөлөн эдлэлийн үлдэгдэл өссөнөөс ихэвчлэн шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 741.1 сая, нийт зарлагыг 741.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 117.5 сая төгрөгөөр бууруулж, 623.6 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь хэмнэлтийн зарчимд нийцүүлэн хангамж бараа материалын зардлыг 23.5 сая,

нормативт зардлыг 44.5 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 52.8 сая төгрөгөөр тус тус бууруулан баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг 623.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 623.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 622.1 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1.4 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хэмнэлт/	Биелэлт /хэмнэлт/
	70705-Шүүхийн шийдвэр гүйцэтгэл				
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	614,820.9	613,774.2	1,046.7	99.8
2	80220- Холбооны суваг ашигласны хөлс	1,534.8	1,114.8	420.0	72.6
3	80229- Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	6,726.9	6,725.6	1.3	99.9
4	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	420.0	420.0	0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд 19.5 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллага нь төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
	70705-Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	2022	100.0	90.3	623,567.6	622,099.5

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бараа материалын бүртгэл, биет бус хөрөнгийн талаар гарсан шийдвэртэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн 01/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 630.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үр дүнгийн урамшуулал огт олгоогүй, ажиллагсдын хүүхдийн бэлэг өгөх зардал гаргаагүй, албан томилолтоор ажилласан үед томилолтын зардал олгоогүй зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг хамаараагүй.

Энэ хуулийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардлаас нийт 1,5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, төсөвт буцаан төвлөрүүлжээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хууль, журамд заасан мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, бүрэн байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тухайн байгууллагад тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0				
Албан шаардлага	0				
Зөвлөмж	0				
Нийт дүн	0				

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тухайн байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй агуулахын газар эзэмших эрхийг хүчингүй болгосон аймгийн Засаг даргын 2021 оны А/547 тоот захирамж гарсан боловч уг эрхийн бүртгэл нь тухайн байгууллагын хөрөнгийн бүртгэлээс хасагдаагүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хөрөнгө нь төрийн өмч тул аймгийн Засаг даргын шийдвэрээр эзэмших эрхийг хүчингүй болгох нь үндэслэлгүй гэж ТӨБЗГ-аас мэдэгдсэн. Газар эзэмших эрхийг Засаг даргын захирамжаар өөр этгээдэд олгож болох тул бүртгэлд байгаа хөрөнгө оршин байхгүй болох магадлалтай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй боловч байгууллагын буруутай үйлдлээс шалтгаалаагүй асуудлыг залруулах 1 зөвлөмж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг улам сайжруулах талаар 1 зөвлөмж өглөө.

Аудитаар зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тавиагүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газар эзэмших эрхийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Газар эзэмших эрхийг хүчингүй болгосон аймгийн Засаг даргын захирамж гарсан ч уг хөрөнгийг бүртгэлээс хасаагүй. Энэ асуудлаар зөвшөөрөл авахаар ШШГЕГ-т хандсан боловч тус байгууллагын хөрөнгө нь төрийн өмчид хамаарах тул аймгийн Засаг даргын шийдвэрээр хөрөнгийн хөдөлгөөн хийхгүй гэсэн хариу өгчээ.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийн бүртгэлийн асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт албан ёсоор уламжилж, шийдвэрлүүлэх ажил зохион байгуулах

2. Бараа материалын бүртгэлд ашиглаж буй маягттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатах тослох материалын тооцоог сар бүр хийж, жолооч нарын тооцоог бодож хэтрэлт хэмнэлтийг тооцож байгаа ч Сангийн сайдын тушаалаар батлагдсанаас өөрчлөгдсөн маягтаар, мөнгөн дүнгээр хийдэг.

Өгсөн зөвлөмж: Шатах тослох материалыг бараа материалд бүртгэх болон зарцуулахдаа шатахууны хэмжих нэгжээр тусгаж, жолоочийн тооцоог батлагдсан маягтаар хөтөлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газар эзэмших эрхийг хүчингүй болгосон аймгийн Засаг даргын захирамж гарсан ч уг хөрөнгийг бүртгэлээс хасаагүй.	1		1						1		1	

Шатах тослох материалын тооцоог сар бүр хийж, жолооч нарын тооцоог бодож хэтрэлт хэмнэлтийг тооцож байгаа ч Сангийн сайдын тушаалаар батлагдсанаас өөрчлөгдсөн маягтаар, мөнгөн дүнгээр хийдэг.	1				1				1			1
Дүн	2		1		1				2			2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН



